



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.3, 47.4, 47.6 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг үйлчилгээ хийсний дагуу зайлшгүй засвар үйлчилгээ хийх нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан хяналт, мэдээллийн систем, тоолуурын нэгдсэн системийн сэлбэг хэрэгсэл худалдан авахад нийлүүлэгч компанийг хуулийн дагуу сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Ганзориг Тоолуурын системийн инженер

Нарийн бичгийн дарга:
Ц.Цэрэндулам Системийн автоматик, тооцооны инженер

Гишүүн: Н.Бат-Өлзий ХМС-ийн программын инженер

2. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд салбарын мэргэжлийн холбооны төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёр төлөөлөгч оролцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Ганзориг/-нд зөвшөөрсүгэй.

3. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төлөвлөж, техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх, сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох заавар, журмын дагуу гүйцэтгэхийг Үнэлгээний хороо /Ц.Ганзориг/-нд даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, санхүүгийн алба /Ц.Мартгэрэл/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР